

СУРГАЛТЫН ЯВЦАД ОЮУТНУУДАД ХАНДЛАГА ТӨЛӨВШҮҮЛЭХ БАЙДЛЫГ СУДЛАХ

Р.Гантуяа¹, О.Батжаргал¹, О.Мөнхөө¹, Ш.Батзүсэм¹,
¹АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль

Хүлээн авсан огноо: 2021.10.22

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор Д.Алтайхүү

Үндэслэл

Үр дүнд суурилсан боловсролын хөтөлбөрийн үр дүнг тодорхойлохдоо хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, чадвар хандлагыг тодорхой зааж өгсөн байдаг. Хэдийгээр сургалтын хөтөлбөрт хандлагыг ийнхүү чухалчилан зааж өгсөн байдаг боловч түүнийг ямар агуулгын хүрээнд хэрхэн яаж үнэлж, тодорхойлох асуудал бүрхэг хэвээр байгаа юм. Оюутан нэг бүрийг хөгжүүлэх, багшлах арга зүй технологид тулгамдаж буй асуудлыг судлах, тэргүүний арга технологитой багш нарын арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажил эхлээд байна.

Түлхүүр үг: Сургалт, хандлага, төлөвшил

Судалгааны ажлын зорилго

Сургалтын явцад оюутнуудад хандлага төлөвшүүлж байгаа байдлыг судлах.

Судалгааны аргазүй

БСШУЯ-наас гаргасан “ЕБС-ын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журмыг хэрхэн хэрэгжүүлэх вэ?” Зөвлөмжид үндэслэн хүүхдүүдийг төлөвшүүлэх арга туршлагаас шударга, хариуцлагатай байх, идэвх зүтгэлтэй байх, өөрийгөө хөгжүүлэх, нинжин сэтгэлтэй болгох гэсэн 5 чиглэлээр асуумжийг авч баяжуулан боловсруулав. АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь Анагаах Ухааны Сургуулийн 32 багш, МУИС-ийн Завхан сургуулийн 16 багшаас хаалттай болон нээлттэй анкет 11 асуулгаар судалгааг авсан.

Судалгааны үр дүн

Судалгаанд 2-32 жил ажилласан, насны хувьд 25-55, хүйсийн хувьд эмэгтэй-79%, эрэгтэй -21%, АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь Анагаах Ухааны Сургуулийн 32, МУИС-ийн Завхан сургуулийн 16 нийт 48 багш хамрагджээ.

Хугацаа хоцорсон даалгаврыг шалгана гэхдээ онооноос нь хасаж тооцдог асуултанд АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь Анагаах Ухааны Сургуулийн багш нар – 25%, МУИС-ийн Завхан сургуулийн багш нар -69% тийм гэж хариулсан байна. Оюутнуудын сурах идэвх зүтгэлийг үнэлэхэд хэцүү байдаг \13%\ Оюутнуудад өөрийгөө хөгжүүлэх хандлагыг төлөвшүүлэхдээ олон нийтийн ажил зохиох нь илүү үр дүнтэй \25%\ гэж

судалгаанд оролцсон 2 сургуулийн багш нар ижил хариулжээ. Хандлагын бүтэц, бүрэлдэхүүн хэсгийг 1942 онд А. Смит танин мэдэхүйн(когнитив), сэтгэл хөдлөлийн (аффектив), зан үйлийн (конатив) хэмээн тодорхойлсон байдаг бол судалгаанд хамрагдсан багш нар өөрийн биеэр үлгэрлэх, хамт олон дотор нь төлөвшүүлэх, дэг журам тогтоох, шаардлага тавих зэргээр зан үйлийн буюу конатив хэлбэрийн арга замуудыг илүүд үзэж байгаа нь сонирхол татлаа.

Дүгнэлт

МУИС-ийн Завхан сургуулийн багш нар нь судалгааны ажил, төсөлт ажилд хамруулах байдлаар, АШУУИС-ийн Говь- Алтай аймаг дахь Анагаах Ухааны Сургуулийн багш нар оюутнуудад яриа таниулга хийх, ярилцлага, хэлэлцүүлэг зохиох зэргээр танин мэдэхүйн (когнитив) аргыг илүүтэй хэрэглэж оюутнуудад хандлага төлөвшүүлдэг байна. МУИС-ийн Завхан сургуулийн багш нар ажиглалт, ярилцлага, анкет, асуумж, судалгаа, бүтээлийн сан(бүтээлч даалгавар, бие даан гүйцэтгэх ажлууд) гэсэн аргуудыг хэрэглэдэг бол АШУУИС-ийн Говь- Алтай аймаг дахь Анагаах ухааны сургууль багш нар ярилцлага, бүтээлийн сан(бие даалтын ажлууд, ирц, идэвх чармайлтын оноо, даалгаврын гүйцэтгэл, оролцоо) ажиглалтын (хичээлийн бэлтгэл, эмнэлгийн хувцас хэрэглэлээ өмссөн байдал зэрэгт үнэлгээ өгч) зэрэг аргуудыг хэрэглэн оюутнуудын хандлагыг үнэлдэг байна.

ABSTRACT

To determine the outcome of result-oriented education curriculum, knowledge, skills and attitude acquired through the curriculum must be well defined. Although attitude is defined seriously in the curriculum, how to assess the attitude in which content of curriculum is not clear. Here we assessed the state of attitude instilling in students of Gobi-Altai Medical School of MNUMS and Zavkhan School of NUM. The study was conducted in order to study the individual character development in students, problems faced by lecturers in teaching methodology and spread the best practices of teachers with outstanding teaching methods. The study included teachers aged 25-55 years who have 2-32 years of teaching experience and 32 are from the Gobi-Altai medical school while